



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/389

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 25 дугаар захирамж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А-268 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн коронавируст халдвар (КОВИД-19)-тэй тэмцэж буй Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ард түмэнд найрсаг хөршийн хувиар хандивласан 30 мянган толгой хонийг холбогдох хууль тогтоомжийн дагуу цуглуулах үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: И.Доржсүрэн -Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: С.Цэдэнбалжир –Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

А.Нямдаваа – Аймгийн Засаг даргын дэргэдэх Мал эмнэлгийн газрын дарга

Б.Батбилэг –Аймгийн Онцгой байдлын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч


С.Дуламсүрэн – Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга

О.Ганбат – аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Ц.Төмөрбат –Аймгийн Засаг даргын дэргэдэх Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн улсын ахлах байцаагч

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100873